



## "ЦЭСБ-АУДИТ" ХХК

Итгэл бодох бүртгэл, хяналтын  
итгэмжлэгдсэн хөдөлмөрийн байгууллага

4258743, Дархан Уул аймэг, Дархан сум, 10-р баг  
5-р хороо, "ЛХА" ХХК-ий 2 дэлхэр 65 тоот  
Утас/факс: 95112689, 99275858  
Э-мэйл: zesh.audit@gmail.com

005.09.24 № 2/082  
Танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хараат бус аудиторын тайлан

### ЗӨРЧИЛГҮЙ ДҮГНЭЛТ

"Түшиг-Уул" ХК-ийн 2024 оны 12 дүгээр сарын 31-ний өдрөөрх тайлан тэнцэл, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

#### Дүгнэлт

Бидний дүгнэлтээр тус компанийн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн, зөв бодитой үзүүлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудыг дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

#### Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд багтсан хэдий ч санхүүгийн тайлан ба аудиторын тайланд багтаагүй мэдээллээс бүрдэнэ. Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй тул бид бусад мэдээлэлд баталгаажуулалт гаргахгүй. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай эсвэл аудитын явцад бидний олж авсан ойлголттой нийцэж байгаа эсэх эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болзошгүй эсэхийг тодорхойлох явдал юм. Дээр дурьдсан горимуудыг гүйцэтгэх явцад энэхүү бусад мэдээлэлтэй холбоотой материаллаг буруу илэрхийлэл илрүүлсэн бол бид тайлагнах шаардлагатай байдаг. Үүнтэй холбоотой тайлагнах аливаа зүйлс байхгүй.

## Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор компанийн удирдлагын хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, толилуулах нь Компанийн удирдлагын хариуцлага байна. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлага орно.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

## Аудиторуудын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гарган, өөр аливаа нэг этгээдэд биш Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох та бүхэнд тайлагнах нь бидний хариуцлага юм. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олс авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшиний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

ЗАХИРАЛ



Ч.ЦЭРЭННАДМИД



**"ТҮШИГ УУЛ" ХХК**  
**АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**  
 /2024 оны 12 дугаар сарын 31-ээрхи/

/ төгрөгөөр/

| Үзүүлэлт                                              | 1/1/2024                | 12/31/2024              |
|-------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| <b>Эргэлтийн хөрөнгө</b>                              |                         |                         |
| Мөнгөн ба түүнтэй адилтгах хөрөнгө                    | 27,347,666.28           | 69,164,709.20           |
| Дансны авлага                                         | 619,844,680.58          | 925,391,728.78          |
| Татвар, НДШ-ийн авлага                                |                         |                         |
| Бусад санхүүгийн хөрөнгө                              |                         |                         |
| Бараа материал                                        | 42,233,120.67           | 43,348,220.18           |
| Урьдчилж төлсөн зардал /тооцоо                        | 655,075,435.74          | 646,007,808.74          |
| Бусад эргэлтийн хөрөнгө                               |                         |                         |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө |                         |                         |
| <b>Эргэлтийн хөрөнгө</b>                              | <b>1,344,500,903.27</b> | <b>1,683,912,466.90</b> |
| <b>Эргэлтийн бус хөрөнгө</b>                          |                         |                         |
| Үндсэн хөрөнгө                                        | 721,869,355.62          | 636,347,327.06          |
| Биет бус хөрөнгө                                      | 656,276.05              | 512,827.75              |
| Урт хугацаат ХО                                       |                         |                         |
| Бусад биет бус хөрөнгө                                |                         |                         |
| <b>Эргэлтийн бус хөнгөний дүн</b>                     | <b>722,525,631.67</b>   | <b>636,860,154.81</b>   |
| <b>Нийт хөрөнгийн дүн</b>                             | <b>2,067,026,534.94</b> | <b>2,320,772,621.71</b> |
| <b>Богино хугацаат өр төлбөр</b>                      |                         |                         |
| <b>Өр төлбөр</b>                                      |                         |                         |
| Дансны өглөг                                          | 40,799,283.17           | 115,597,949.01          |
| Цалингийн өглөг                                       | 3,780,615.00            | 5,462,240.00            |
| Татварын өглөг                                        | 342,569,359.62          | 456,554,195.98          |
| НДШ-ийн өглөг                                         | 3,384,875.04            | 3,910,674.20            |
| Банкны богино хугацаат зээл                           |                         |                         |
| Хүүгийн өглөг                                         |                         |                         |
| Ноогдол ашгийн өглөг                                  |                         |                         |
| Урьдчилж орсон орлого                                 | 5,000,000.00            |                         |
| Нөөц /өр төлбөр/                                      |                         |                         |
| Богино хугацаат өр төлбөр                             |                         |                         |
| <b>Өр төлбөрийн дүн</b>                               | <b>395,534,132.83</b>   | <b>581,525,059.19</b>   |
| Урт хугацаат өр төлбөр                                |                         |                         |
| Бусад урт хугацаат өр төлбөр                          |                         |                         |
| <b>Өр төлбөрийн дүн</b>                               | <b>395,534,132.83</b>   | <b>581,525,059.19</b>   |
| Төрийн                                                |                         |                         |
| Хувийн өмч                                            | 43,457,700.00           |                         |
| Хувьцаат                                              |                         | 43,457,700.00           |
| Нэмж төлөгдсөн капитал                                |                         |                         |
| Дахин үнэлгээний нэмэгдэл                             | 1,518,409,944.21        | 1,518,409,944.21        |
| Эздийн өмчийн бусад хэсэг                             |                         |                         |
| Хуримтлагдсан ашиг                                    | 109,624,757.90          | 177,379,918.31          |
| <b>ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>                              | <b>1,671,492,402.11</b> | <b>1,739,247,562.52</b> |
| <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН</b>                     | <b>2,067,026,534.94</b> | <b>2,320,772,621.71</b> |



**"ТҮШИГ УУЛ" ХХК**  
**АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ТАЙЛАН**  
 /2024 оны 12 дугаар сарын 31-ээрхи/

|                                                         | / төгрөгөөр /       |                      |
|---------------------------------------------------------|---------------------|----------------------|
| ҮЗҮҮЛЭЛТ                                                | 1/1/2024            | 12/31/2024           |
| Борлуулалтын орлого/цэвэр/                              | 858,824,381.82      | 947,672,036.56       |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг                         | 748,838,925.63      | 751,433,216.28       |
| Нийт ашиг                                               | 109,985,456.19      | 196,238,820.28       |
| Түрээсийн орлого                                        |                     |                      |
| Хүүгийн орлого                                          |                     |                      |
| Ноогдол ашгийн орлого                                   |                     |                      |
| Бусад орлого                                            | 84,085,491.80       | 74,133,768.34        |
| Борлуулалт, Маркетингийн зардал                         | 77,099,213.35       | 87,790,084.70        |
| Ерөнхий ба удирдлагын зардал                            | 115,648,820.03      | 107,298,992.35       |
| Санхүүгийн зардал                                       |                     |                      |
| Бусад зардал                                            |                     |                      |
| Гадаад валютын ханшийн зөрүү олз/ гарз/                 |                     |                      |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/              |                     |                      |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/            |                     |                      |
| Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/         |                     |                      |
| Бусад ашиг ( алдагдал)                                  |                     |                      |
| <b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>                       | <b>1,323,914.61</b> | <b>75,263,511.57</b> |
| Орлогын татварын зардал                                 | 132,391.46          | 7,528,351.16         |
| <b>Татварын дараах ашиг алдагдал</b>                    | <b>1,191,523.15</b> | <b>67,755,160.41</b> |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал |                     |                      |
| <b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>                | <b>1,191,523.15</b> | <b>67,755,160.41</b> |
| Бусад дэлгэрэнгүй орлого                                |                     |                      |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү             |                     |                      |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү                      |                     |                      |
| Бусад олз (гарз)                                        |                     |                      |
| <b>Орлогын нийт дүн</b>                                 |                     |                      |
| Нэгж хувицаанд ногдох суурь ашиг (алдагдал)             | -                   | -                    |



**"ТҮШИГ УУЛ" ХХК**  
**АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**  
**(2024 оны 12 дугаар сарын 31-ээрхи)**

/ төгрөгөөр/

| Үзүүлэлт                                                 | Өмч                  | Эздийн өмчийн<br>бусад хэсэг | Хөрөнгийн дахин<br>үнэлгээний<br>нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг    | Нийт дүн                |
|----------------------------------------------------------|----------------------|------------------------------|-------------------------------------------|-----------------------|-------------------------|
| <b>2022 оны 12 р сарын 31-ээрх<br/>үлдэгдэл</b>          | <b>43,457,700.00</b> | <b>-</b>                     | <b>1,518,409,944.21</b>                   | <b>108,433,234.75</b> | <b>1,670,300,878.96</b> |
| Нягтлан бүртгэлийн бодлогын<br>өөрчлөлтийн нөлөө алдааны |                      |                              |                                           |                       | -                       |
| Запруулсан үлдэгдэл                                      | 43,457,700.00        | -                            | 1,518,409,944.21                          | 108,433,234.75        | 1,670,300,878.96        |
| Тайлант үеийн цэвэр ашиг                                 |                      |                              |                                           | 1,191,523.15          | 1,191,523.15            |
| Өмчид гарсан өөрчлөлт                                    |                      |                              |                                           |                       | -                       |
| <b>2023 оны 12 р сарын 31-ээрх<br/>үлдэгдэл</b>          | <b>43,457,700.00</b> | <b>-</b>                     | <b>1,518,409,944.21</b>                   | <b>109,624,757.90</b> | <b>1,671,492,402.11</b> |
| Нягтлан бүртгэлийн бодлогын<br>өөрчлөлтийн нөлөө алдааны |                      |                              |                                           |                       | -                       |
| Запруулсан үлдэгдэл                                      | 43,457,700.00        | -                            | 1,518,409,944.21                          | 109,624,757.90        | 1,671,492,402.11        |
| Тайлант үеийн цэвэр ашиг<br>алдагдал                     |                      |                              |                                           | 67,755,160.41         | 67,755,160.41           |
| Өмчид гарсан өөрчлөлт                                    |                      |                              |                                           |                       | -                       |
| Зарласан ногдол ашиг                                     |                      |                              |                                           |                       | -                       |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн<br>хэрэгжсэн дүн             |                      |                              |                                           |                       | -                       |
| <b>2024 оны 12 р сарын 31-ээрх<br/>үлдэгдэл</b>          | <b>43,457,700.00</b> | <b>-</b>                     | <b>1,518,409,944.21</b>                   | <b>177,379,918.31</b> | <b>1,739,247,562.52</b> |



**"ТҮШИГ УУЛ" ХХК**  
**АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
**/2024 оны 12 дугаар сарын 31-ээрхи/**

/төгрөгөөр/

| Үзүүлэлт                                                      | 1/1/2024              | 12/31/2024              |
|---------------------------------------------------------------|-----------------------|-------------------------|
| <b>Мөнгөн орлогоын дүн</b>                                    | <b>874,690,970.00</b> | <b>1,012,379,722.00</b> |
| Бэрээ борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого                  | 874,690,970.00        | 1,012,379,722.00        |
| Бусад мөнгөн орлого                                           |                       |                         |
| <b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>                                | <b>850,247,048.26</b> | <b>970,562,679.08</b>   |
| Ажиллагаадад төлсөн                                           | 35,198,200.00         | 67,541,765.00           |
| НДБайгууллагад төлсөн                                         | 10,145,869.52         | 19,019,355.84           |
| Бэрээ материал худалдан авахад төлсөн                         | 44,268,512.94         | 72,242,200.27           |
| Ашиглалтын зардалд төлсөн                                     | 140,493,285.00        | 144,314,020.91          |
| Түлш шатахуун тээврийн хэрэгсэлд төлсөн                       | 346,321,687.00        | 439,135,859.00          |
| Хүүний төлбөрт төлсөн                                         |                       | 30,000,000.00           |
| Татварын байгууллагад төлсөн                                  | 12,970,810.98         | 14,112,576.07           |
| Дээтгэлийн төлбөрт төлсөн                                     |                       |                         |
| Бусад мөнгөн зарлага                                          | 280,856,902.84        | 184,196,901.99          |
| <b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>            | <b>24,443,921.74</b>  | <b>41,817,042.92</b>    |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ             |                       |                         |
| <b>Мөнгөн орлогоын дүн</b>                                    | <b>-</b>              | <b>-</b>                |
| Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого                             |                       |                         |
| Биет бус хөрөнгө борлуулсаны орлого                           |                       |                         |
| Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого                           |                       |                         |
| Бусдад олгосон эзэл мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт         |                       |                         |
| Хүлээн авсан хүүний орлого                                    |                       |                         |
| Хүлээн авсан ногдол ашиг                                      |                       |                         |
| <b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>                                | <b>-</b>              | <b>-</b>                |
| Хөрөнгө оруулалт олж болгохад                                 |                       |                         |
| Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн               |                       |                         |
| Бусдад олгосон эзэл болон урьдчилгаа                          |                       |                         |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ       | -                     | -                       |
| <b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>              |                       |                         |
| <b>Мөнгөн орлогоын дүн</b>                                    | <b>-</b>              | <b>-</b>                |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан           |                       |                         |
| Хувьцаа болон өмчийн бүсэд үнэт цаас гаргаснаас хүлээн авсан  |                       |                         |
| Валютын ханшийн тацалтгүйн ашиг                               |                       |                         |
| <b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>                                | <b>-</b>              | <b>-</b>                |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө                  |                       |                         |
| Валютын ханшийн зөрүү                                         |                       |                         |
| <b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b> | <b>0.00</b>           | <b>-</b>                |
| <b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>                               | <b>24,443,921.74</b>  | <b>41,817,042.92</b>    |
| <b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>        | <b>2,903,744.54</b>   | <b>27,347,666.28</b>    |
| <b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>       | <b>27,347,666.28</b>  | <b>69,164,709.20</b>    |